



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/543

Улаанбаатар хот

Гадаад сургалт зохион байгуулах,
зардал гаргах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, 8.1.23 дах заалт, 25 дугаар зүйлийн 25.12 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.1, 14.2.3, 14.2.5 дах заалт, Эрүүл мэндийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2014 оны 119 дүгээр тушаалаар баталсан "Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам"-ын 1.5 дах заалт, Сангийн сайдын "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 2011 оны А/188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, тусламж үйлчилгээний чанар, халдварын сэргийлэлтийн чадавхийг сайжруулах" гадаад сургалтад хамрагдах эмч, мэргэжилтний нэрсийг нэгдүгээр, гадаад сургалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гадаад сургалтад шаардагдах зардлыг энэ онд батлагдсан төгсөлтийн дараах сургалтын зардлаас гаргаж, сургалтыг Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Я.Амаржаргал/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

082084

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 12 сарын 02 өдрийн

А/1543 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, тусламж үйлчилгээний чанар, халдварын сэргийлэлтийн чадавхийг сайжруулах” сургалтын удирдамж

Үндэслэл:

Эрүүл мэндийн салбарт эмчилгээ, оношилгооны шинэ техник, технологи, нянгийн эсрэг өргөн үйлчилгээтэй химийн эм, бэлдмэлүүд, ариутгах, халдваргүйжүүлэх бодисууд өргөн нэвтэрч байгаа нь анагаах ухааны нэг ололт боловч нөгөө талаас эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар тархах нөхцөлийг бүрдүүлж байгаа тул халдвар хамгааллын чиглэлээр шинээр нэвтэрч буй арга технологийг судалж, нутагшуулах асуудал чухлаар тавигдаж байна.

2018 онд Япон Улсын Токио хотноо болсон “Өвчтөний аюулгүй байдал”-ын асуудлаархи дэлхийн сайд нарын 3 дугаар чуулга уулзалтаар тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох замаар үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатайг онцлон тэмдэглэсэн бөгөөд уг уулзалтын үеэр “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх Токиогийн тунхаглал”-ыг баталсан.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага ба Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газраас өвчтөний аюулгүй байдал болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын салшгүй хэсэг хэмээн үзэж “Олон улсын өвчтөний аюулгүй байдлын хамтын санаачлага (Global Patient Safety Collaborative)”-ыг эхлүүлээд байна.

Монгол Улс нь Олон улсын өвчтөний аюулгүй байдлын хамтын санаачлагыг хэрэгжүүлэх 4 орны нэгээр шалгарсан бөгөөд 2019-2021 онд “Global Patient Safety Collaborative” зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхой ажлууд хийхээр төлөвлөөд байна. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын нэг чухал хэсэг нь халдварын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар байдаг.

Сүүлийн 4 жилийн хугацаанд эрүүл мэндийн байгууллагын чанарын алба, халдварын сэргийлэлт хяналт хариуцсан мэргэжилтнүүдээс хариуцсан чиг үүргийн хүрээнд гадаад сургалтад хамрагдаагүй байгаа тул халдварын сэргийлэлт, хяналт болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, чанарын чиглэлээр энэ удаагийн сургалтыг зайлшгүй зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Зорилго:

Халдварын сэргийлэлт хяналт болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, чанарын чиглэлээр сургалтанд хамруулах, олон улсын туршлагыг судлах, мэдээлэл солилцох, шинээр нэвтэрч буй арга технологийг нутагшуулах санал боловсруулах

Хугацаа:


2019 оны 12 дугаар сард

Үр дүн:

Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр эмч, мэргэжилтнүүдийн ур чадвар дээшилсэн байна.

A/543

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 12 сарын 20 өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, тусламж үйлчилгээний чанар,
халдварын сэргийлэлтийн чадавхийг сайжруулах” сургалтад
хамрагдах эмч, мэргэжилтний нэрс

№	Овог нэр	Регистрийн дугаар	Эрүүл мэндийн байгууллага, албан тушаал
1	Д.Золзаяа	УЕ80020102	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын хэлтсийн дарга
2	Б.Уянга	ЧП84012405	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын мэргэжилтэн
3	Б.Отгончимэг	ГИ95030302	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын мэргэжилтэн
4	Ж.Нямсүрэн	РГ75110907	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгээс шалтгаалах халдвартай тэмцэх, сэргийлэх тасгийн дарга
5	Ц.Уянга	ЧС74091823	Улсын хоёрдугаар төв эмнэлгийн тархвар судлаач
6	Г.Нарантуяа	СР81121005	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгээс шалтгаалах халдвартай тэмцэх, сэргийлэх тасгийн тархвар судлаач
7	Д.Гэрэлцэцэг	ЖЬ83102305	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгээс шалтгаалах халдвартай тэмцэх, сэргийлэх тасгийн тархвар судлаач
8	Д.Баттогтох	ФА76110601	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Микробиологийн тэнхимийн эрхлэгч
9	Ц.Тунгалагтамир	УЗ74122101	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн
10	П.Мидриймаа	ИЭ70033049	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэжилтэн
11	Б.Баасанжав	ДБ76112605	Хавдар судлалын үндэсний төвийн чанарын албаны дарга
12	Э.Энхжаргал	МЮ62070101	Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн
13	Ч.Дуламрагчаа	ФА75033169	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн чанарын менежер
14	Ч.Оюунтунгалаг	ЖНЮ68040469	Дорнод аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга